



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг өөрчлөн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/752 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын “Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

С.Оюунцэцэг

Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Зөвлөлийн гишүүд:

З.Отгонбат

Ахлах нягтлан бодогч

Б.Түвшинтөр

Мэдээллийн, технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Янжинлхам

Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Дөлгөөн

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

А.Алимаа

Нярав

2. “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг хэрэгжүүлж, биелэлтийг удирдлагын зөвлөлийн хуралд хагас жил тутам тайлагнаж ажиллахыг зөвлөл /С.Оюунцэцэг/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн хэлтсийн дарга Г.Мөнхнасан-д даалгасугай
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/135 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГҮНДСАМБУУ